

ОРОСЫН АРХИВУУДААС АВЧИРСАН БАРИМТЫН ТОЙМ

Д.ЗОЛБОО*

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 1992 оны 3 дугаар сарын 7-нд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгуулагдсан архивын салбарт хамтран ажиллах монгол, оросын комиссын шугамаар Монгол Улс (БНМАУ), Оросын Холбооны Улс (ЗСБНХУ)-ын харилцаанд холбогдох баримт бичгүүдийг нээн илрүүлэх ажил нэлээд тогтмолжиж үр дүнгээ өгч байна.

Монгол улсын Засгийн газраас ихэд анхаарсны дүнд энэ чиглэлээр судалгааны хэсэг байгуулагдан ажиллаж ирэв. 1993-2000 онд нийт 6 данс, 3000 орчим хуудас баримтыг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор С.Дамдинсүрэн нарын бүрэлдхүүнтэй монголын судлаачдын хэсэг Оросын нийгэм-улс төрийн түүхийн улсын архив (Российский государственный архив социально политической истории) буюу хуучнаар ЗХУКН-ын Төв архив, Оросын шинэхэн түүхийн улсын архив (Российский государственный архив новейшей истории), Оросын холбооны улсын Ерөнхийлөгчийн (ГАРФ) архив зэрэг нээлттэй болгосон архивиас илрүүлэн хуулбарлан авчирсан юм. Цөөн тооны баримтыг хамтарсан комиссын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан архивын баримт бичиг солилцоо, баримтын үзэсгэлэн байгуулах зэрэг арга хэмжээний үеэр Оросын талаас манайд шилжүүлсэн байна.

Эдгээр баримтын Коминтерний холбогдолтой хэсгийг РГАСПИ-ын 495 дугаар сан хөмрөг буюу Коминтерний Гүйцэтгэх хорооны хөмрөгийн дараах данснудаас авчээ.

- д.1 Коминтерний гүйцэтгэх хороо КИГХ
- д.2 КИГХ-ны Тэргүүлэгчдийн газар
- д.3 КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газар
- д.4 КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын Улс төрийн комисс
- д.19 КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга И.Я.Пятницкийн Нарийн бичгийн дарга нарын газар
- д.73 Г.Димитровын янз бүрийн орны коммунист намуудын

* Д.Золбоо - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

- удирдлагатай харилцсан бичгүүд
- д.152 Монгол Ардын Хувьсгалт Нам
- д.154 КИГХ-ны Дорнодын хэлтэс, Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар
- Молотовын баримтын данснууд зэрэг болно.

Эдгээр баримт нь Монголын талаар дээрх газраас гаргасан тогтоол шийдвэр, удирдамж, тэдгээрийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, Коминтернийн Монгол дахь төлөөлөгчдийн бичсэн мэдээлэл, захидал, хэлсэн үг, Монголын нам төрийн удирдлагаас Коминтернд илгээсэн мэдээ тайлан, Коминтерний хурал зөвлөгөөнд монголын төлөөлөгчдийн оролцсон тухай мэдээ баримт, тэдний тавьсан илтгэл, хэлсэн үг зэргээс зонхилон бүрдэж байгаа юм.

Уг баримтуудын ихэнх нь 1991 оны наймдугаар сард ЗХУКН-ын архивуудыг нээлттэй болгох хүртэл нууцлагдан хадгалагдаж байсан, эрдэм шинжилгээний эргэлтэд бараг орж байгаагүй онцлог баримтууд юм.

Монгол Ардын Нам байгуулагдсны дараахан буюу 1920 оны намар тус намын төлөөлөгчид тусламж эрэх хэргээр Зөвлөлт Орос улсад очихдоо ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн Монгол-төвдийн хэлтэст МАН-ын зорилтыг тодорхойлж, тусламж эрсэн бичиг гардуулсан, мөн 1921 оны хавар анх удаа Коммунист Интернационалын Гүйцэтгэх хорооны (КИГХ) урилгаар Коминтерний III Их хуралд тус намын төлөөлөгчид оролцсон зэрэг үеэс МАХН ба Коминтерний хоорондын холбоо, хамтын ажиллагаа тогтон хөгжсөн юм. МАХН нь 1921 оноос Коминтернд зөвлөгч эрхтэй талархагч байгууллага болон нэгдэж түүний төлөөлөгчдийг Намын Төв Хорооны дэргэд урьж ажиллуулах, Их хуралдаа оролцуулах, Коминтерний их хурал, түүний гүйцэтгэх хорооны бүгд хурал болон зохих байгууллагуудын хуралд өөрийн төлөөлөгчдөө оролцуулах, мэдээлэл солилцох зэрэг хэлбэрээр хамтран ажиллаж байжээ. Энэхүү холбоог бэхжүүлэхэд 1921-1922 онд ажиллаж байсан Эрхүү хот дахь Коминтерний Алс дорнод дахь нарийн бичгийн дарга нарын газар, Москва дахь Дорно дахины хэлтэс (1922-1926), Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар (1926-1928), Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар (1928-1935), КИГХ-ны байгууллагууд, 1924-1932 онд МАХН-ын дэргэд тогтмол ажиллаж байсан КИГХ-ны төлөөлөгч нар ихээхэн үүрэг гүйцэтгэж байжээ.

Коминтерний тусламж дэмжлэгийг Монголын тусгаар тогтнолын үйл хэрэгт дөхөм үзүүлэх хүчин зүйлийнх нь хувьд МАН, түүний удирдагчид нааштай хүлээн авч, идэвхтэй хамтран ажиллахыг эрмэлзэж байсныг баримт бичгүүд тодорхой харуулж байна.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол орон феодалын ёсыг халж, өмчийн олон хэлбэрт тулгуурлан үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, үндэсний эв нэгдлийг хангах, улс орныхоо тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд Монголын төр засгийн удирдагчид гол анхаарлаа хандуулж байсан билээ. Гэвч Коминтерний бодлогод хэт зүүний үзэл давамгайлж Монгол орны үндэсний ардчилсан хөгжлийн чиг хандлагыг хянан үзэх, монголын удирдагчдыг баруунтан, зүүнтэн хэмээн сөргөлдүүлэх замаар монголын нийгмийн дотор социалист үзэл суртал, туршлагыг хүлээн авч хэрэгжүүлэх хүчнийг бий болгох талаар Коминтерн идэвхтэй үйл ажиллагаа явуулсан юм. Үүний үр дүнд МАХН-ын VII их хурал монгол орныг нийгэм журмын ёсонд оруулахыг зорих тухай шийдвэр гаргасан, үндэсний ардчилсан үзэл санааг баримталдаг хүмүүсийг монголын нам, төрийн удирдлагаас шахан гаргаснаар Монголд социализм байгуулах туршилтыг шууд удирдах боломж Коминтерний өмнө хэрхэн нээгдснийг харуулсан эх баримтын хүчин төгөлдөр хуулбараар нь үзэж болно.

1993, 1994 онд голлон Коминтерний баримт бичгийг судлан илрүүлж Монгол улсын Үндэсний төв архивт олон зуун архивын хадгаламжийн нэгж бүхий 445 дугаар сан хөмрөг болгон бүрдүүлж тэдгээрээс сонголт хийж “Коминтерн ба Монгол” гэдэг баримт бичгийн эмхтгэлийг (40 орчим хэвлэлийн хуудас) 1996 онд хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон байна. Хэдий тийм боловч тус архивын уг сан хөмрөгт хэвлэгдээгүй олон зуун баримт бичиг хадгалагдаж байна.

Манай судлаачдын хэсэг Коминтерний нууцлагдсан баримтыг илрүүлэх ажлыг ийнхүү үндсэнд нь дуусгаад 1998 оноос ОХУ-ын архивуудад Бүх Холбоотын Коммунист (большевикуудын) Намын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, Зохион байгуулах товчоо, Нарийн бичгийн дарга нарын газраас Монголын талаар гаргаж байсан шийдвэр, түүний төв, орон нутгийн байгууллагуудаас Монголтой харилцаж байсан баримт материалыг судлан илрүүлэх ажлыг 1999, 2000 онуудад үргэлжлүүлэн хийж гүйцэтгэв. Эдгээр ажлыг ОХУ-ын РГАСПИ-ын 1, 17, 19, 74, 76, 78, 82, 144, 372, 495, 558, 644-р сан хөмрөг, РГАНИ-ын 5, 89-р сан хөмрөг, ГАРФ-ын 130, 3316, 7315-р сан хөмрөг, АВГРФ-ын 06-р сан хөмрөгүүдэд голлон явуулжээ. Энэ ажлын үр дүнд Монгол улсын Үндэсний төв архивт 1920-1952 оныг хамарсан баримтуудаар 445-р дансны 5, 6-р данс үйлдэн судалгаа шинжилгээнд ашиглахад бэлэн болгожээ. Эдгээр баримт нь голдуу урьд өмнө нь эрдэм шинжилгээний эргэлтэнд орж байгаагүй юм. Жишээ нь, В.И.Сталины 70 насны ойд Монголын ард түмнээс илгээсэн бэлгийн жагсаалт, Монгол ажиллаж байсан Зөвлөлтийн сургагч, зөвлөх нарын бүртгэл, маршал Х.Чойбалсангийн

нас барсантай холбогдсон эмнэлгийн дүгнэлт, УТТ-ны хурлын тэмдэглэл, тогтоол зэргийг нэрлэж болох юм. Мөн эдгээр баримт бичгээс сонголт хийж “БХК(б)Н ба Монгол” I боть (1920-1952) гэсэн баримтын эмхтгэлийг 2001 онд хэвлүүлэх бэлтгэл ажил эхлээд байна.

Хоёр тал харилцан тохиролцсоны дагуу “ЗХУКН ба Монгол” (1953-1990) баримтын илрүүлэлтийг 2001-2002 онд ОХУ-ын архивуудад хийж баримтын хуулбараар Үндэсний Төв Архивын дээрх сан хөмрөгийг баяжуулахын хамт энэхүү сэдвээр баримтын эмхтгэл бэлтгэж 2002 онд хэвлүүлэхээр болсон ажээ.

Уг баримтуудын данс бүртгэл үйлдэхдээ уул баримтуудын үйлдэгдсэн эх хэл дээр буюу орос хэл дээр хийжээ. Тэгэхдээ хадгаламжийн нэгжийн гарчигт баримтын гарчгийг ашиглахыг чухалчилсан байх бөгөөд харин цөөн тохиолдолд баримтын агуулга, нэр төрөл, шинж, зохиогч, хүлээн авагч зэргийг харгалзан шинэ гарчиг өгчээ. Мөн бүртгэлийн тайлбар хэсэгт тухайн баримтуудын эх нь хадгалагдаж буй Оросын архивиудын (РЦХИДНИ, ГАРФ, РГАСПИ, РГАНИ г.м) нэр, хөмрөг, данс, хадгаламжийн нэгж, хуудасны тоог тодорхой бичсэн байгаа нь Монголын тал уг баримтуудыг хуулбарлан авахдаа тэдний зөвшөөрөлгүйгээр хувилахгүй, бусдад шилжүүлэхгүй, баримтыг бүрэн буюу хэсэгчилсэн хэлбэрээр ном, хэвлэлд тавихгүй, радио телевизээр сурталчлахгүй байх, зөвхөн түүх судалгааны ажилд ашиглах, тэгэхдээ тухайн баримтын тус архивын шифрийг тодорхой тавьж байх үүрэг хүлээсэнтэй холбоотой юм.

Эдгээр баримтыг бүртгэсэн дансыг нэг бүрчлэн дурьдвал,

1, Коминтерн ба Монгол Улсын (МАХН) харилцааны холбогдолтой байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэл гэсэн 1918-1993 оны хоорондох 168 хадгаламжийн нэгж бүртгэсэн 38 хуудас бүхий дансыг 1997 онд үйлдэж батлуулсан.

2, БНМАУ /Монгол Улс/ ба ЗСБНХУ /Орос Улс/-ын хоорондын улс төрийн харилцаа, цэргийн хамтын ажиллагаанд холбогдох байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэл гэсэн 1920-1981 оны хоорондох 89 хадгаламжийн нэгж бүртгэсэн 17 хуудас бүхий дансыг мөн 1997 онд үйлдэж батлуулсан.

3, БНМАУ /Монгол Улс/ ба ЗСБНХУ /Орос Улс/-ын хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын талаар хамтын ажиллагаанд холбогдох байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэл гэсэн 1921-1979 оны хоорондох 94 хадгаламжийн нэгж бүртгэсэн 18 хуудас бүхий дансыг мөн 1997 оны 5-р сард үйлдэж батлуулсан.

4, Архивын салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссын Монголын хэсгийн үйл ажиллагаанд холбодолтой байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэлд 4 хуудсанд 18

хадгаламжийн нэгж бүртгэсэн байна.

5, Монгол Коминтерний харилцаанд холбогдолтой байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд 1918-1958 оны хооронд холбогдох 114 хадгаламжийн нэгжийг 2000 онд батлуулсан.

6, Коммунист намын архиваас авчирсан баримтын бүртгэлд 1920-1990 оны хооронд холбогдох 38 хадгаламжийн нэгжийг бүртгэж 2001 онд бүртгэсэн байна.

Дээрх архивиудаас авчирсан баримт бичигт Монгол, Оросын түүхчид боловсруулалт, сонголт хийж 2000 онд “Монгол-Зөвлөлтийн соёл шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1960)” гэсэн /34 хх/ баримт бичгийн эмхтгэлийг хамтран гаргаж нэгэнт уншигч, судлагч олны хүртээл болгосон билээ.

Эдгээр баримтууд нь XX зууны Монголын түүхэн үнэнийг нээн харуулах, түүхийн цагаан толбо, түүх судлал дахь гажуудлыг арилгахад ихээхэн ач холбогдолтой юм.

Ийнхүү манай эрдэмтэн судлаачид түүх судлал дахь тайлагдаагүй олон чухал асуудлыг шинэ сонирхолтой баримтад тулгуурлан түүхэн үнэний үүднээс судлах нэгэн шинэ суурь сурвалжтай болж байна.

Ашигласан материал

1. “Коминтерн ба Монгол” 1996, Улаанбаатар
2. “Монгол-Зөвлөлтийн соёл шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1960)” УБ, 2000
3. Үндэсний Төв Архивын 445-р сан хөмрөгийн баримт